

ГЛОБАЛ НЭГДЭЛ

ТОГТВОРТОЙ
ХӨГЖЛИЙН
ТАЙЛАН
2023

ГЛОБАЛ НЭГДЭЛ

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТАЙЛАН 2023

АГУУЛГА

1. ОРШИЛ

- Алсын хараа
- Уриа
- Үнэт зүйлс
- Бизнес Үйл Ажиллагааны чиглэл
- Бүтэц зохион байгуулалт

📁 3 - 5

2. НҮБ-ЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГООС ДЭМЖИХ ЗОРИЛТУУД

📁 6 – 8

3. ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТ, ҮЙЛ ЯВЦ

📁 9 – 30

ОРШИЛ

Глобал Нэгдэл ХХК болон салбар компаниуд болох Глобал Телеком ХХК, Глобал Электроникс ХХК, Глобалсмайт Сольюшн ХХК, БТ Дистрибьюшн ХХК нь Монгол Улсын “Алсын хараа 2050” болон бусад урт хугацааны бодлого, зорилтуудыг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулах, бизнесийн үйл ажиллагаагаа НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилго, зорилтуудтай уялдуулан байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын тогтолцоог үе шаттайгаар нэвтрүүлэн хэрэгжүүлж байна. Мөн бид байгууллагын бодлого, журмуудыг БОНЗ-ын зарчимтай уялдуулж Хөдөлмөрийн тухай хуулийн хүрээнд шинэчлэн хэрэгжүүлж байна.

Түүнийхээ хүрээнд 2023 онд хийж, хэрэгжүүлсэн дотоод болон гадагшаа чиглэсэн ажлуудынхаа үр дүнг БОНЗ, Тогтвортой байдлын тайлагналын удирдамжийг баримтлан тайлагнав.

Алсын хараа

Бид, эрүүл амьдралын хэв маяг, технологийн шинэчлэл, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг цогцлоон, нийгмийн тогтвортой хөгжлийн төлөө манлайлагч байна.

Уриа

Амьдралын хэв маягаа чанаржуул

Үнэт зүйлс

G	Grow Өсөн дэвж
L	Lead Манлайл
O	Openness & Integrity Шударга, ёс зүйтэй бай
B	Be Passionate Хүсч тэмүүл, санаачил
A	Accountability Хариуцлагатай бай
L	Loyalty & Appreciate Үнэнч бай, таларх

N	Network & Collaborate Хамтар
E	Excel Давамгайл
G	Good communication Сайн холбогд, харилц
D	Do & Learn fast Түргэн суралц, түргэн хий
E	Expertise & professionalism Чадварж, мэргэш
L	Lean Sustainability Нийгэм, байгаль орчноо хайрла

Хэрэгжүүлэгч

- Глобал Нэгдэл ХХК
- Глобал Телеком ХХК
- Глобал Электроникс ХХК
- Глобалсмарт Сольюшн ХХК
- БТ Дистрибьюшн ХХК

Бизнес үйл ажиллагааны чиглэл



Бүтэц зохион байгуулалт



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО-ын хамрах хүрээ



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО-ын уриа

Хөгжлөөс хэн ч үл хоцрох ёсгүй. “**NO-ONE** left behind”

НҮБ-ЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГООС ДЭМЖИХ ЗОРИЛТУУД



2.1 2030 он гэхэд ядуурлыг эцэс болгож, хүн бүрийг, ялангуяа ядуу болон эмзэг бүлгийн хүмүүс, түүний дотор нялхсыг эрүүл, шим тэжээллэг, хүрэлцэхүйц хоол хүнсийг жилийн турш авах боломжоор хангах

2.3 Нэмүү өртөг шингээх, хөдөө аж ахуйн бус ажил эрхлэлтийг бий болгох үүднээс газар, үр ашигтай бусад баялаг, мэдээлэл мэдлэг, санхүүгийн үйлчилгээ, зах зээл, нөөц боломжийг ашиглах эрх тэгш, баталгаатай боломжийг бүрдүүлэх замаар жижиг хэмжээний хүнсний үйлдвэрлэгчид, ялангуяа нутгийн иргэд, гэр бүлийн фермерийн аж ахуй эрхлэгчид, малчид, загасны аж ахуй эрхлэгчдийн хөдөө аж ахуйн бүтээмж, орлогыг 2030 он гэхэд 2 дахин нэмэгдүүлэх



3.2 2030 он гэхэд урьдчилан сэргийлэх боломжтой нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг арилгах

3.4 2030 он гэхэд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, түүнийг эмчлэх замаар халдварт өвчнөөс үүдэлтэй цаг бусаар нас барах явдлыг гуравны нэгээр бууруулах

3.9 2030 он гэхэд аюултай химийн бодис, агаар, ус, хөрсний бохирдол, халдвараас болж үхсэн, өвдсөн хүмүүсийн тоог үлэмж хэмжээгээр бууруулах



4.A Хүүхэд, хөгжлийн бэрхшээл, жендерийн мэдрэмжтэй боловсролын байгууллагыг бэхжүүлэн сайжруулж, хүн бүрийг аюулгүй, хүртээмжтэй, үр дүнтэй суралцах орчноор хангах



5.5 Улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралын хүрээнд шийдвэр гаргах бүх үе шатанд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох, манлайлан ажиллах тэгш боломжоор эмэгтэйчүүдийг хангах



6.3 2030 он гэхэд дэлхийн түвшинд бохирдлыг бууруулах, цэвэрлэгдээгүй бохир усны хувь хэмжээг хоёр дахин бууруулах, усыг дахин боловсруулж, цэвэршүүлэн хэрэглэх явдлыг [х] хувиар нэмэгдүүлэх замаар усны чанарыг сайжруулах



7.1 2030 он гэхэд боломжийн, найдвартай, орчин үеийн эрчим хүчний үйлчилгээгээр хүн бүрийг хангах

7.3 2030 он гэхэд эрчим хүчний үр ашиг, хэмнэлтийн хурдыг дэлхийн түвшинд хоёр дахин нэмэгдүүлэх



8.2 Эдийн засгийг төрөлжилт, технологийн шинэчлэл, инновациар дамжуулан, түүний дотор өндөр өртөг шингэсэн, ажиллах хүч ихээр шаарддаг салбаруудад голлон анхаарч эдийн засгийн бүтээмжийн өндөр түвшинд хүрэх

8.3 Бүтээмжтэй үйл ажиллагаа, зохистой ажлын байр бий болгох, аж ахуй эрхлэх, бүтээлч байдал, инновацийг дэмждэг хөгжлийн чиг баримжаатай бодлогыг хөхүүлэн дэмжиж, санхүүгийн үйлчилгээг хүртээмжтэй болгох замаар бичил, жижиг, дунд бизнесийг албан ёсны болгож, тэдгээрийн өсөлтийг дэмжих

8.5 2030 он гэхэд эрэгтэй, эмэгтэй бүх хүн, түүний дотор залуу болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бүрэн, бүтээмжтэй ажил, зохистой хөдөлмөр эрхлүүлж, адил үнэ цэнэтэй ажилд адилхан цалин хөлс олгох

8.6 2020 он гэхэд ажил эрхэлдэггүй, боловсрол эсвэл сургалтад хамрагдаагүй залуучуудын эзлэх хувийг үлэмж хэмжээгээр бууруулах

8.7 Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг хориглох, устгахад чиглэлээр шуурхай, үр дүнтэй арга хэмжээ авч, албадан хөдөлмөр хийлгэх явдлыг арилгаж, бүх хэлбэрийн хүүхдийн хөдөлмөр, түүний дотор хүүхдийг цэрэг болгон элсүүлэх, ашиглах явдлыг 2025 он гэхэд эцэс болгох

8.8 Хөдөлмөрлөх эрхийг хамгаалах, бүх ажил хөдөлмөр эрхлэгчид, түүний дотор улирлын түр ажилтан, ялангуяа улирлын түр эмэгтэй ажилтан, аюултай хөдөлмөр эрхэлдэг ажилтнуудад аюулгүй, найдвартай ажиллах орчныг бий болгох



10.2 2030 он гэхэд нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, арьс өнгө, яс үндэс, удам угсаа, шашин шүтлэг, эдийн засгийн болон бусад байр сууриасаа үл хамааран хүн бүрийг нийгэм, эдийн засаг, улс төрийн амьдралд эрх тэгш оролцох боломжоор хангаж, дэмжих

10.3 Ялгаварлан гадуурхсан хууль журам, бодлого, зан заншлыг халж, энэ талын хууль тогтоомж, бодлого, үйл ажиллагааг хөхүүлэн дэмжих замаар тэгш боломж бололцоог бүрдүүлж, тэгш бус байдлыг бууруулах

10.4 Санхүү, цалин, нийгэм хамгааллын бодлогыг батлан хэрэгжүүлж, тэгш байдлыг аажмаар хангах



11.4 Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хадгалан хамгаалах арга хэмжээг сайжруулах



12.5 2030 он гэхэд хог хаягдлаас сэргийлэх, түүнийг бууруулах дахин боловсруулах, дахин хэрэглэх замаар хог хаягдал бий болгож буй хэмжээг үлэмж хэмжээгээр бууруулах

12.8 2030 он гэхэд хүн бүр тогтвортой хөгжил, байгаль дэлхийтэйгээ зохицон амьдрах амьдралын хэв маягийн талаар холбогдох мэдээлэл, мэдлэгтэй болсон байх



15.2 Бүх төрлийн ойн тогтвортой менежментийг нэвтрүүлэх явдлыг хөхүүлэн дэмжих, цөлжилтийг зогсоох, муудсан ойг сэргээх, ойжуулах, моджуулах ажлыг олон улсын түвшинд [х] хувиар нэмэгдүүлэх



16.5 Авлига, хээл хахуулийн бүх хэлбэрийг үлэмж хэмжээгээр багасгах

ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТ, ҮЙЛ ЯВЦ

Өнөөгийн хурдацтай өөрчлөгдөж буй ертөнцөд тогтвортой хөгжил нь салбар бүрийн бизнес эрхлэгчдийн хувьд чухал тэргүүлэх чиглэл болоод байна. Глобал Нэгдэл ХХК нь бизнесийн чиглэл, үйл ажиллагаа, албан журмын хүрээнд НҮБ-ын Тогтвортой Хөгжлийн Зорилго зарчмуудыг үйл ажиллагаандаа уялдуулан ажиллаж байна.

2023 оноос хойш Глобал Нэгдэл ХХК нь салбар компаниудын дотоод журам, үйл ажиллагаанийхаа хүрээнд болон шинэ бизнес, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхдээ “НҮБ-ийн Тогтвортой Хөгжлийн Зорилт – 2030” тусгасан 17 зорилгоос дараах 13 зорилго, 26 дэд зорилтуудыг баримтлан ажиллаж байна.



Монгол улсын хүн амын хүнсний ногооны хэрэглээний ихэнх хувийг импортоор оруулж ирж буй хүнсний ногоонууд хангаж байгаа бөгөөд дийлэнх хувийг Хятад улс эзэлж байна. Монгол улс хүнсний ногооны хэрэглээгээ дотооддоо бүрэн хангаж дийлэхгүй [х] хувийг импортоор хангаж байгаа нь үндэсний хүнсний аюулгүй байдалд нөлөөлөхөөр хэмжээнд байна. Дотооддоо уламжлалт аргаар нарийн ногоо тариалж байгаа боловч энэ нь хортон шавьжнаас хамгаалах хор ашиглах, хүчтэй бордоо ашиглан ургуулах зэрэг олон сөрөг талтай бөгөөд манай орны эрс тэс хүйтэн уур амьсгалд зөвхөн дулааны улиралд тариалалт хийх боломжтой хязгаарлагдмал арга болоод байна.

Глобал Нэгдэл “Бизнес Хөгжлийн Газар” нь 2023 оноос эхлэн “Газар тариалангийн үйл ажиллагаа, хүнсний ногоо тариалалт”-ийг онолын болон технологийн түвшинд судлан дотооддоо төслийн баримт бичиг бүрдүүлэн ажиллаж байна. Мөн туршилтын тариалалт хийн эхний байдлаар амжилттай ургац хураан авсан.

Ургац хураалтын зургуудаас:






Агаарын бохирдлын асуудал бий болсноос хойш түүний нөлөөнд хүүхдүүд хамгийн ихээр өртөж байгааг тогтоосон. Үндэсний хэмжээнд 5 хүртэлх насны хүүхдүүдийн эндэгдлийн хоёр дахь шалтгаанд уушгины хатгалгаа орж байна. Иймд бид Чанартай агаар төслөөр дамжуулан дотоод агаарын чанарыг сайжруулж 5 хүртэлх насны хүүхдийн өвчлөл, эндэгдлийг багасгахад хувь нэмэр оруулан ажиллаж байна.


Уг ажлын хүрээнд Глобал Электроникс ХХК нь Panasonic брэндийн Nanoe X технологи бүхий эйр кондишн /агааржуулагч/, Air-E зэрэг агааржуулагч төхөөрөмжүүдийг зах зээлд нийлүүлэн айл гэр болон албан байгууллагуудын дотоод агаарын чанарыг сайжруулахад хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

Бид 2023 онд зөвхөн дээрх технологид суурилсан 65ш эйр кондишн борлуулсан ба эдгээр газруудад өдөрт дунджаар 473 хүн орж гарах тооцоололтой байна.

**NanoeX технологи бүхий эйр кондишн борлуулалт
/талбайн төрлөөр, хувь/**



**NanoeX технологи бүхий эйр кондишн борлуулалт
/өдөрт дунджаар хамрагдах хүний тоогоор, хувь/**



Эдгээрээс гадна дурдвал:

№	Суурилуулалт хийсэн огноо	Суурилуулсан байгууллага	Хамрах хүрээ
1	2019-2022 он	БЗД-ийн 63-р цэцэрлэг	70-80м талбай бүхий 6 анги танхим
2	2020-2021 он	3-р эмнэлэг мэс заслын өрөөнд,	3-р эмнэлэг үйлчлүүлэгч болон багаж хэрэглэлийн ариутгалд
3	2020-2021 он	Глобал Нэгдэл	Оффис
4	2022 он	BDF llc	Adidas showroom болон оффис
5	2022-2023 он	Солонго хараа нүдний эмнэлэг	Лазер мэс заслын өрөө

2020-2021 онд бид “Чанартай агаар” төслөөр дамжуулан Улсын Гуравдугаар Төв Эмнэлэг, Сүхбаатар дүүргийн эмнэлэг, Шархадны хүүхдийн эмнэлэг зэрэгт туршилт явуулан эерэг үнэлгээтэй хариу гарсан ба туршилтын талаарх дэлгэрэнгүйг баталгаажуулан төслийн материал болгон хадгалсан. Мөн эдгээрээс “Улсын Гуравдугаар Төв Эмнэлэг”-ийг сонгон туршилтаар байршуулсан Air-E төхөөрөмжийг үнэ төлбөргүй бэлэглэсэн.

Бид цаашид ч мөн үйл ажиллагаагаа өргөжүүлэн эрүүл аюулгүй, цэвэр агаар бүхий орчинг худалдан авагч, харилцагчиддаа бий болгон ажиллахаар төлөвлөж байна.



4 ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ



Суралцагчдыг анхаарал төвлөрүүлэн суралцахад агаарын чанар, хэм маш ихээр нөлөөлдөг тул Чанартай агаар төслөөр дамжуулан суралцах орчны агаарын чанарыг сайжруулан ажиллаж байна.

Эдгээрээс дурдвал:

- ✓ Нийслэлийн 63-р цэцэрлэг
- ✓ Гурван Тамир сургууль
- ✓ British English School
- ✓ Олон Улсын Дунд Сургууль

зэрэг сургалтын байгууллагуудад агаар цэвэршүүлэгч, агааржуулагч төхөөрөмжүүдийг суурилуулан ажиллаад байна.


5 ЖЕНДЕРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ



Бид “Хөдөлмөрийн Дотоод Журам” болон “Ёс Зүйн Журам” зэрэгтээ жендерийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой зүйл заалтыг оруулж өгсөн байдаг ба журмын хүрээнд өдөр тутамдаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Мөн 2023 онд Глобал Нэгдэл-ийн удирдлагуудын хүрээнд хүйсийн тэгш харьцааг баримтлан ажиллаж,

12-р сарын байдлаар нийт хүний нөөцийн 46.8% -ийг эмэгтэй ажилчид бүрдүүлэн ажиллаж байна.



“Хөдөлмөрийн Дотоод Журам”-ийн

- ✓ 11.1.1,
- ✓ 11.2.3,
- ✓ 11.3 дахь заалт

“Ёс Зүйн Журам”-ийн 5.7 дахь заалтыг тус тус мөрдлөг болгон ажилладаг.

Глобал Электроникс ХХК нь үндсэн үйл ажиллагаа болон тус зорилтын хүрээнд олон арга хэмжээ авч хэрэгжүүлэн ажиллаж байна.

Бид олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн дараах брэндийн ус шүлтжүүлэгч, зөөлрүүлэгч бүтээгдэхүүнийг албан ёсны эрхтэйгээр борлуулж байна:

- ✓ Panasonic болон
- ✓ Fujiiryoki брэндийн ус шүлтжүүлэгч
- ✓ Mizumon брэндийн ус зөөлрүүлэгч бүтээгдэхүүн зэрэг юм.

Хүчил, шүлтийн тэнцвэржилттэй усыг тогтмол хэрэглэх нь эрүүл мэндэд тустай бөгөөд ялангуяа шүлтлэг ус нь хүний биед агуулагдах элдэв өвчний, тэр дундаа хорт хавдар, чихрийн шижин, цусны даралт ихсэх, арьсны үрэвсэл зэрэг өвчнүүдийн эх үүсвэр болдог илүүдэл зүйлс, бие организмд хуралдсан хорт бодисыг гадагшлуулахад тустай. Цэвэршүүлсэн ус нь бүхий л хэрэглээнд тохиромжтой.



2023 оны хугацаанд дараах бараа бүтээгдэхүүнүүдийг борлуулсан байна.

- Нийт 71 ус шүүгч аппарат,
- Нийт 15 ус зөөлрүүлэгч, 3 хог шүүгч.



Нэг өрхийн ам бүлийн дундаж тоог 4 гэж үзвэл 2023 онд ойролцоогоор 344 хүн эрүүл, аюулгүй, баталгаат ундны усаар хангагдсан байна.

Компанийн үйл ажиллагааны хүрээнд 2023 онд дараах өдөрлөг, үйл ажиллагааг нээлттэй, олон давтамжтайгаар зохион байгуулсан байна. Эдгээр үйл ажиллагаанууд нь усны зөв хэрэглээ, усны хэмнэлт, ундны усны чанар, эрүүл ахуйн шаардлага зэргийг бүтээгдэхүүнээр дамжуулан иргэдэд мэдлэг мэдээлэл олгох зорилгоор зохион байгуулагдсан.

Үйл ажиллагаануудаас дурдвал:



Дэлхийн усны өдөр буюу 2023 оны 3-р сарын 25 ны өдөр River Tower-ийн 1 давхарт үнэ төлбөргүй усны хатуулаг, шүлтлэг байдлыг тестлэх өдөрлөг амжилттай зохион байгуулан, иргэдэд усны хэрэглээний талаарх мэдээлэл хүргэж ажиллав.

Усны өдөрлөгийн зургуудаас:



Мөн бид 2023 онд өөрийн нэр дээр “Mizumon” брэндийг үүсгэн байгуулан “Оюуны өмчийн газар”-т албан ёсоор бүртгүүлсэн. Mizumon брэндийн хамгийн анхны бүтээгдэхүүн нь “Ус зөөлрүүлэгч” юм.

Ус зөөлрүүлэгч бүтээгдэхүүний тухайд:

Дэлхийн олон улс өөрийн оронд баримтлал болгоод буй ДЭМБ-с зөвлөсөн усны хатуулаг чанарын хэмжигдэхүүн стандарт нь хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөлөл, үр дүн зэргээс шалтгаалан дээрх PPM хэмжигдэхүүнээр тодорхойлогдож байна.

Харин манай улсын хувьд хатуулаг чанарын хэмжигдэхүүн стандарт нь ОУ-н стандартаас хэт хол зөрүүтэй байгаа нь бидний эрүүл мэнд, өдөр тутмын усны хэрэглээнд урт хугацаандаа хор хөнөөл учруулах эрсдэлтэй юм.

Ийм учраас Монгол улс усны чанар стандартын хэмжигдэхүүнээ ОУ-ын түвшинтэй нийцүүлэх нэн шаардлагатай. Үүний хүрээнд бид олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хамгийн сүүлийн үеийн технологи бүхий ус зөөлрүүлэгч бүтээгдэхүүнийг зах зээлд шинээр нэвтрүүллээ.

“ШУА-ийн Газарзүй-Геоэкологийн хүрээлэн, Усны нөөц, ус ашиглалтын салбар” – аас боловсруулан гаргасан “Газар доорх усны чанарын” судалгааны үр дүн болон Ус Сувгийн Удирдах Газрын “Усны чанарын шинжилгээ” мэдээлэл зэрэгт үндэслэн дараах судалгааг гаргав.

Шинжилгээ судалгаанд дүүргүүдээс СХД-31/33/, БГД-7, ЧД-9, СБД-11, БЗД- 26, ХУД хамгийн их буюу 43 худаг, уст цэг хамрагдсан.


Эрдэсжилт, мг/л			Хатуулаг, мг-экв/л		
ангилал	Худгийн тоо	эзлэх %	ангилал	Худгийн тоо	эзлэх %
Нэн цэнгэг	13	12.90	Маш зөөлөн	8	6.45
Цэнгэг	66	53.25	Зөөлөн	16	12.90
Цэнгэгдүү	33	26.61	Зөөлөвтөр	49	39.52
Давсархаг	8	6.45	Хатуувтар	23	18.55
Давстай	1	0.81	Хатуу	8	6.45
Шорвог	-	-	Маш хатуу	20	16.13
Нийт 126 худаг		100.0	Нийт 126 худаг		100.0

ДЭМБ-с зөвлөсөн хэмжээгээр авч үзвэл хатуу ус юм.

Судалгаанд хамрагдсан худгийн усны эрдэсжилт, хатуулгийн ангилал

ДЭМБ-аас зөвлөж буй хатуулаг усны 121 ppm нэгж нь Монголын стандартаар зөөлөн буюу 2.5 мг-экв/л байна. ОУ-н стандартаар авч үзвэл манай улсын усны хатуулаг 2.5 мг-экв/л –ээс дээш бол хатуу ус юм.

Усыг зөөлрүүлэх давуу тал:



Ус сайн уух нь эрүүл мэндэд онцгой ач холбогдолтой бөгөөд шээсний хүчил шүлтийн тэнцвэрийг зохицуулж, өнгө, нягт болон шээсний үнэрт сайнаар нөлөөлнө, өөрөөр хэлбэл, өдөрт дунджаар 2000 мл ус, тэр дундаа болж өгвөл **шүлтлэг шинж чанар өндөртэй, зөөлрүүлсэн ус** ууж хэвших нь шээсний Ph ийг өглөөд 6.5 аас оройдоо Ph 7.5 хооронд байлгахад тустай.

АУ-ны Доктор,
Монгол Улсын Ахлах
зэргийн зөвлөх
Аюушийн Энх-Амар:

- ✓ Цөсний чулуу үүсэх хүчин зүйлийг багасгана
- ✓ Зөөлөн ус нь бөөрний эрүүл мэндэд тустай
- ✓ Хоолны шингэцэд сайнаар нөлөөлж, хоол боловсруулах замын эрхтэн тогтолцоонд эерэг нөлөө үзүүлдэг
- ✓ Зөөлөн ус нь арьсыг зөөлөн, эрүүл болгодог.
- ✓ Зөөлөн ус нь үсийг зөөлөн, гялалзсан, эрүүл байхад тусалдаг.

Эх сурвалж: [ikon.mn](#), [RWI](#), [NIH](#)

Ус зөөлрүүлэгч бүтээгдэхүүн нь урт хугацаандаа эрүүл мэндэд маш эерэгээр нөлөөлдөг

болохыг дээрх судалгаа шинжилгээнүүд харуулж байна.

Зөөлрүүлсэн усны ач холбогдлыг таниулах, сурталчилах зорилгоор усны өдөрлөг зохион байгуулж тус өдөрлөгөөр

- ✓ “Шарга морьт”-ийн ойр ойрчмын зуслан
- ✓ “Хан-Уул E-Mart”

зэрэг байршлуудад тус бүр 2 өдрийн нээлттэй арга хэмжээ зохион байгуулан хүрэлцэн ирсэн иргэдийн ундны усыг тестлэн, зөвлөгөө мэдээлэл хүргэж ажиллав.

Mizumon өдөрлөгийн зургуудаас:



Глобал Нэгдэл-ийн “Хөдөлмөрийн Дотоод Журам”-ийн АРВАН НЭГ: НҮБ-ИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ

ХДЖ-ийн энэхүү бүлэгт:

- ✓ Жендерийн эрх тэгш байдлыг хангах,
- ✓ Эдийн засгийн өсөлт, зохистой хөдөлмөрийг дэмжих
- ✓ Тэгш бус байдлыг бууруулах
- ✓ Хуурай газрын эко системийг хамгаалах
- ✓ Энх тайван, шударга ёсыг цогцлоох
- ✓ Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх ажиллах

зэрэг 6 дэд бүлэг агуулагддаг ба байгууллагын хүрээнд өдөр тутмын үйл ажиллагаандаа энэхүү журмыг мөрдлөг болгон ажилладаг.

1. Ажлын байр, албан тушаалын ангилал

Глобал Нэгдэл-ийн хэмжээнд 2023 онд 30 төрлийн үүрэг чиглэл бүхий батлагдсан ажлын байр байгаагаас дараах 4 нь шинээр бий болсон.

- Вэб хөгжүүлэгч
- Мерчандайз дизайнер
- Хуулийн зөвлөх
- Засвар үйлчилгээний инженер

Нийт ажлын байрыг албан тушаалын шатлалаар ангилвал дараах байна.




Нийт ажлын байрны 60% нь мэргэжилтэн, менежерүүдээс бүрдэж байна. Эдгээрээс дурдвал:

- Нягтлан бодогч
- Борлуулалтын менежер
- Хүний нөөцийн менежер
- Маркетингийн менежер
- Инженер
- Шинжээч
- Бусад гэх мэт юм.

Цалингийн ангилал нь мөн дээрх албан тушаалын шатлалаас хамараах ба

- ✓ Ш-1,
- ✓ Ш-2,
- ✓ Ш-3,
- ✓ Ш-4 ангиллаар тодорхойлогдож байна.



2. Ажилчдын боловсролын зэргийн мэдээлэл

2023 оны 12-р сарын байдлаар нийт ажилчдын боловсролын зэргийг тоймлогоос дараах байна.




3. Бусад

- Байгууллагын хэмжээнд улирлын болон түр ажлын байр байхгүй.

- Ажиллагсад дунд тусгай хэрэгцээт болон насанд хүрээгүй хүүхэд байхгүй. “Хөдөлмөрийн Дотоод Журам”-ийн 11.2.5 дахь заалтын дагуу Хүүхдийн болон албадан хөдөлмөр эрхлэлтийг хориглосон.
- Байгууллагын хэмжээнд “Хөдөлмөрийн Аюулгүй Байдал, Эрүүл Ахуйн” журам мөрдөгдөн ажиллаж байна.
ХАБЭА -н ажлын байрны эрсдлийн үнэлгээгээр HVAC багийнхан болон Инженер Техникийн ажилтнууд өндөрт ажиллах шаардлага гардаг ба ХАБЭА ажилтан П. Даваадорж ээлжит ба ээлжит бус АА /аюулгүй ажиллагааны/ зааварчилгааг тогтмол өгч ажилладаг.

4. Оффисын орчин



Panasonic TK7585E
Ус шүлтжүүлэгч



Panasonic Air-E
Агаар цэвэршүүлэгч



Panasonic
Air condition

Бид хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, оновчтой, үр ашигтай, олон талт хөдөлмөрийн харилцааг бий болгохоор зорьж байна. Үүний хүрээнд ажиллах таатай, уян хатан орчныг бүрдүүлж оффисын байрандаа үе шаттайгаар засвар шинэчлэлт хийн өрөө бүрд Panasonic брэндийн эйр кондишн, 20 мк.в тутамд Air-E агаар цэвэршүүлэгч суурилуулан агаарын таатай нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна. Үүнээс гадна бид усны зөв хэрэглээг дотооддоо ч мөн хэрэгжүүлэн ажиллаж байгаагийн нэг нь Panasonic TK7585E – Ус шүлтжүүлэгч төхөөрөмж юм.

Мөн Fujiiryoki брэндийн олон үйлдэлт массажны сандал, Technics брэндийн пянз тоглуулагч зэргийг амралтын хэсэгтээ байршуулан ажилчдынхаа эрүүл мэнд, амралт чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрүүлэх нөхцөлүүдийг бүрдүүлэн, ажиллах орчныг сайжруулах арга хэмжээ авч байна.



Глобал Нэгдэл-ийн дотоод журмын хүрээнд ялгаварлан гадуурхахыг хориглосон хэд хэдэн заалтыг мөрдөн ажиллаж байна.

“Ёс зүйн журам”-ийн холбогдох зүйл заалтуудаас:

4.1.4 Эрх тэгш байдлын хүрээнд: Хамт ажиллаж буй ажилтнууд, үйлчлүүлэгч, иргэн бүртэй адил тэгш, алагчлалгүй харьцах;

5.2 Харилцагчтай эелдэг, адил тэгш, хүлээцтэй, хүндэтгэлтэй харьцаж, хамт олон дотор нөхөрсөг, нээлттэй, эелдэг уур амьсгал бүрдүүлэн ажиллах;

5.7 Бусдыг яс, үндэс, угсаа, хэл, нас, хүйс, боловсрол, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, албан тушаал, мэдлэг, туршлага, эрүүл мэндийн байдал, шашин шүтлэг, үзэл бодол, улс төрийн харьяаллаар нь ялгаварлан гадуурхахгүй байх;

5.9.2 Үйлчлүүлэгч, харилцагч, бусад ажилтантай харьцахдаа зүй бус, бүдүүлэг зан авир гаргах, доромжлох, хэрүүл хийх, айлган сүрдүүлэх, үзэл бодлоо тулгах зэргээр бусармаг авирлах, ажлын байранд танхайрах, зодолдох, бэлгийн дарамт учруулах, хүйсээр ялгаварлан гадуурхах, дарамтлах, хавчин гадуурхах, эрхшээлдээ байлгахыг оролдох, гүтгэх, нэр хүндийг гутаах; зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

6.1.8 Албан тушаалын давуу талаа ашиглан бусдын нэр хүндэд халдах, хууль бус томилгоо, ажил үүргийн хуваарилалт хийх, үнэлэлт дүгнэлт өгөх зэргээс зайлсхийх, хамт олны дунд таагүй уур амьсгал үүсгэх аливаа үйл, үйлдэлд оролцохгүй, хөхүүлэн дэмжихгүй байх;

7.2 Харилцагч нартаа ижил тэгш боломж, бололцоо олгон хамтран ажиллах бөгөөд харилцагчийнхаа бизнесийн нууцыг чандлан хамгаална;

Мөн “Хөдөлмөрийн Дотоод Журам”-ийн

- 11.1.1,
- 11.2.3,
- 11.3 -т тус тус тэгш бус байдлыг бууруулахтай холбоотойгоор зүйл заалт батлан, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Глобалсмарт Сольюшн ХХК нь үйл ажиллагааны үндсэн чиглэл, тогтвортой хөгжлийн зорилт, нийгмийн хариуцлагын хүрээнд олон төрлийн үйл ажиллагаа явуулдаг.

Үүнээс дурдвал:

Тогтвортой Хөгжлийн Зорилт 11.4

Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хадгалан хамгаалах арга хэмжээг сайжруулах

Уг зорилтын хүрээнд бид дараах үйл ажиллагаануудыг явуулсаар ирсэн.

1. Кино наадам

Глобалсмарт Сольюшн ХХК нь 2019 оноос “Кино урлаг, телевиз, кино зураглаачдыг тогтмол дэмжин ажилласаар ирсэн. Үүний хүрээнд дотоодын болон олон улсын чанартай уралдаан тэмцээнүүдэд тогтмол хамтран ажиллаж байгаа юм.



Улаанбаатар Олон Улсын Кино Наадам нь Монголын кино урлагийн салбарыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах, кино уран бүтээлчдийн олон улсын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, дэлхийн нэр хүндтэй наадмуудад шалгарсан кино бүтээлийг Монголын үзэгчдэд хүргэх зорилготойгоор жил бүр зохион байгуулагддаг.


Глобалсмарт Сольюшн ХХК нь Улаанбаатар Олон Улсын кино наадмыг 2019 оноос хойш дэмжин ажиллаж байна. Тус наадмын “Монгол Кино” хэсгийн ялагчид ARRI Alexa 35 зэрэг мэргэжлийн кино зураг авалтын камеруудыг үнэ төлбөргүй ашиглах эрхээр шагнаан урамшуулсаар байна.

“Монгол Кино” хэсгийн ялагчид:

- 2019 он “Би нар” УСК Найруулагч Ж.Сэнгэдорж
- 2020 он “Хөхөө” УСК Найруулагч Ж.Жамъянсүрэн
- 2022 он “Этгээд” УСК – Найруулагч Б.Баатар
- 2023 он “Баавгай болохсон” УСК Найруулагч П.Золжаргал

Мөн эдгээр шагналт кинонууд нь олон улсын кино наадмуудад амжилттай оролцож, дэлхийд Монгол улсын кино урлаг, соёлын өвийг дэлгэрүүлэн таниулж байгаа билээ.

Шагнал гардуулах үеийн зургуудаас:



Глобалсмарт Сольюшн ХХК-ийн борлуулалтын менежер Ж.Намуундарь шагнал гардуулав.



Монголын телевиз, кино зураглаачдын АЛМАЗ наадам нь 2007 оноос хойш зохион байгуулагдаж байгаа ба уг наадам нь Монголын төдийгүй хөрш орнуудын зураглаачид, мөн энэ чиглэлээр суралцаж буй оюутан залуусын өмнө нээлттэй байдгаараа давуу талтай. Номинатид шалгарсан

зураглаачид Алмаз шагнал хүртэхээс гадна "Шилдэгийн шилдэг" зураглаачийг шалгаруулж тухайн жилд болох "CAMERIMAGE" олон улсын наадамд оролцох эрхтэй болдог.

Уг наадамд голчлон дараах номинациудад бүтээлүүдийг шалгаруулдаг.

- Телевизийн зураглал болон клип
- Телевизийн нэвтрүүлэг
- Богино болон бүрэн хэмжээний баримтат кино
- Уран сайхны кино

Бид хамгийн сүүлд 2022 онд зохион байгуулагдсан Зураглаач Г.Батнягт агсаны нэрэмжит Монголын Телевиз, Киноны зураглаачдийн “Алмаз” 5 дахь удаагийн наадамд “Ерөнхий Ивээн Тэтгэгч”-ээр хамтран ажилласан.


Шагнал гардуулах үеийн зургуудаас:



Глобалсмайт Сольюшн ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Оюунтулга шагнал гардуулав.

2. Кино уран бүтээл


Бид мөн кино наадмуудаас гадна кино уран бүтээлүүдийг тогтмол дэмжиж, хамтран ажилласаар байна. 2023 онд дэмжин ажилласан уран бүтээлүүдээс дурдвал:



Хамтран ажилласан
“Бэлчээр Антологи” УСК



Дэмжин ажилласан
“Хонин Холбоо”



Продьюсер
“The Beginning”
богино
хэмжээний кино

3. Ambient Room


Глобалсмарт Сольюшн ХХК нь Монгол уран бүтээлчдээ дэмжих, олон улсад таниулах, чанартай дуугаралт бүхий контент бэлтгэх зорилгоор энэхүү амьд хөгжмийн сувгийг 2022 оноос эхлэн өнөөдрийг хүртэл тогтмол эрхлэн гаргаж байна.

Youtube channel link: [Ambient Room](#)


2023 онд оролцсон уран бүтээлчид:



"The Compass" хамтлагийн гишүүн
Билгүүн




Shoegaze/Dream Pop урсгалаар
тоглодог Elastic Lights хамтлаг



Barkhuu & Myagmartseren




The Tourists хамтлаг



Bluescoopers хамтлаг



Anuk



Sara Teamusician



Monte Blu хамтлаг



San Juniper хамтлаг

2022 оны шинэ жилийн тусгай дугаараас хойш 2023 онд ийнхүү 7 дугаар YouTube сувгаараа дамжуулан гаргаж мөн оны шинэ жилийн баярын тусгай дугаарт 2 хамтлаг урьж оролцуулан үзэгчдэд шууд дамжуулан хүргэсэн байна.

4. Төсөл хөтөлбөр



Төслийн нэр

Глобалсмарт Сольюшн ХХК нь 2021 оноос хойш өнөөдрийг хүртэл Чингис Хаан Үндэсний Музейн бүтээн байгуулалт, тохижуулалтын ажилд төсөл хөтөлбөрөөр дамжуулан оролцон ажилласаар ирсэн.

Төсөл хөтөлбөрүүдээс дурдвал:

Хийсэн үйл ажиллагаанууд

2021-2022 он

XIV.3.3 Чингис Хаан Музейн Үзмэрүүдийг Сэргээн засварлах, сан хөмрөгийг нэмэгдүүлэх төсөл арга хэмжээ

/Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/

Багц-2 Үзмэр, үзүүллэгийн танхимын тоноглол, сан хөмрөгийн хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалтын дагалдах хэрэгслүүд нийлүүлэх гэрээ

Чингис Хаан музей нь давхар бүрт Монголчуудын угсаа гаралын улсууд он цагийн дараалаар явдаг ба тухайн цаг үед ноёрхож байсан улсуудын интерактив газрын зургийг давхар бүрт зориулалтын будгаар будсан хананд проектор тусгаж, өндөр чанартайгаар үзүүлэх, музейн танхимд бусад үзэгчдэд саад болохгүй зөвхөн заасан газарт зогсож тайлбарыг тодоор сонсох боломжтой чиглэлийн чанга яригч зэрэг эх түүхээ өвлүүлэх, сонирхолтой байдлаар мэдлэг олж авахад чиглэсэн орчин үеийн тоног төхөөрөмжүүдийг нийлүүлж, ашиглалтад оруулсан.

Төслийн нэр	Хийсэн үйл ажиллагаанууд
2021-2024 он /Хэрэгжиж байгаа/	
XIV.3.3 Чингис Хаан Музейн Үзмэрүүдийг Сэргээн засварлах, сан хөмрөгийг нэмэгдүүлэх төсөл арга хэмжээ /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/ Багц-3 Үзмэр, үзүүлэлтийн танхимын тоноглол, сан хөмрөгийн хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалтын дагалдах хэрэгслүүд нийлүүлэх гэрээ XIV.3.12 Чингис Хаан Музейн тавилга, тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/ нийлүүлэх гэрээ Багц-8 “Сан хөмрөг сэргээн засварлалтын мэргэжлийн тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл” XIV.3.12 Чингис Хаан Музейн тавилга, тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/ нийлүүлэх гэрээ Багц-14 Үзмэр хадгалж хамгаалах тоног төхөөрөмж	Түүхийн олдвор олно гэдэг маш чухал ч түүнийг зөв орчин, температурт хэрхэн удаан хадгалах вэ, сан хөмрөгийн ажилчид өөрсдөө хэрхэн халдварт өртөхгүй байх вэ гэдэг маш чухал байдаг. Түүхэн эх соёл, өвөө хадгалах, хамгаалахад сан хөмрөг, сэргээн засварлалтын зориулалтын хэрэгслүүдийг нийлүүлж дэлхийн өв соёлд үнэтэй хувь нэмэр оруулсан. Тус зориулалтын хэрэгслүүдээр олдсон олдворуудыг стандартын дагуу хадгалах нь үзмэрүүдийн насжилтийг уртасгах, өв соёлоо хадгалан, хамгаалах, илүү олонд түгээн үзүүлэх, сан хөмрөгийн ажилчид олон жилийн насжилттай олдвороос гарч буй нян бактери зэргээс өөрсдийгөө хамгаалах зэрэг олон талын ач холбогдолтой юм.


Төслийн нэр	Хийсэн үйл ажиллагаанууд
2021-2024 он /Хэрэгжиж байгаа/	
XIV.3.12 Чингис Хаан Музейн тавилга, тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/ нийлүүлэх гэрээ Багц-3 “8 давхарын виртуаль өрөөний тоног төхөөрөмж” XIV.3.12 Чингис Хаан Музейн тавилга, тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/ нийлүүлэх гэрээ Багц-13 Үзүүдлэг дэглэлтийн мэргэжлийн тоног төхөөрөмж	Орчин үед музей үзнэ гэдэг нь туршлага, мэдлэг олж авахаас гадна тэдгээрийг сонирхолтой байдлаар үзэгчид үзэж, судлах тал дээр илүү анхаардаг болсон. Ингэснээр үзэгчид түүхээ илүү сонирхолтой байдлаар үзэж судлах, шинэ туршлага олж авах, дурсамж бүтээх зэрэг олон талын ач холбогдолтой. Үүнээс үүдэн музей үзэж буй үзэгчдэд зориулан дижитал өрөөг орчин үеийн тоног төхөөрөмж, шийдэлтэй бий болгож бий болгож үүний дээр Монголын нууц товчоог эхлэхээс, Чингис Хааныг хаан ширээнд өргөмжлөгдөх хүртэлх амьдрал түүхэн замналыг харуулсан 3D контент бүтээн илүү сонирхолтой байдлаар харуулсан. Үүний үргэлжлэл болсон 2023-2024 оны төсөл дээр контентыг илүү амьд мэт мэдрэмж төрүүлэх зорилготойгоор 4DX эффектүүд нэмж өгснөөрөө түүхийг зөвхөн уншиж судлах бус өөр аргаар судалж бодлыг харуулахыг зорьсон.

Монгол бахархлын өдрийг тохиолдуулан Чингис хаан Үндэсний музейн VIII давхарт Монголын анхны панарома дэлгэц бүхий музейн виртуал өрөө нээлтээ хийсэн билээ.

Чингис хаан Үндэсний музей нь “ГлобалСмарт Сольюшн” ХХК-тай хамтран дэлхийн стандартад нийцсэн музейн виртуал өрөөг Монголдоо анхлан тохижуулж, Япон улсын Panasonic брэндийн проектор болон линз, Герман улсын Neumann брэндийн “Дольби 7,1” дуугаралтын систем, Dataton брэндийн Watchout сервер зэрэг хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт техник технологиор иж бүрэн тоногложээ.

Уг виртуал өрөөнд стандарт видеог 10 дахин томруулсантай тэнцэхүйц өндөр нягтаршил бүхий дүрслэлийг үзүүлснээр үзэгчдэд бодит мэт мэдрэмжийг төрүүлэхээр шийдэл гарган ажиллав.

Виртуал өрөөний зургуудаас:



Глобалсмарт Сольюшн ХХК нь тус музейн бүтээн байгуулалтын нэгээхэн хэсэгт оролцож, музейн 8 танхимаас 6 танхимд дэлхийд тэргүүлэгч Panasonic болон Holosonics брэндүүдийн тоног төхөөрөмжүүдээр мэргэжлийн дуу дүрсний шийдлийг гарган, музейн 3-8 давхарт Panasonic брэндийн нийт 14 проектороор шийдэл гаргаж угсралт суурилуулалт, интеграцийн ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд энэхүү системээр дамжуулан Хүннү гүрнээс эхлээд Чингис хаан болон түүнийг залгамжлагч бага хаадын үеийн түүхэн контентуудыг тод гэрэлтэт, өндөр нягтаршилтай дүрслэл, болон мэргэжлийн цэвэр дуугаралттайгаар тухайн орчинд бүрэн автах мэдрэмж төрүүлэхүйц байдлаар хүргэхээр зорьсон билээ. Тодруулбал Panasonic брэндийн PT-RZ690 – 6000 льюмен гэрэлтэлттэй DLP лазер проектор, ET-DLE020 – ультра-ойрын зайн томруулагч, ET-DLE060 – ойрын зайн томруулагч линз, Geometry manager Pro программ хангамж, сенсор буюу мэдрэгч, Nvidia RTX Quadro – Mosaic технологи бүхий компьютер зэргээр цогц шийдэл гарган суурилуулалт, тохиргоо, интеграцийн ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн билээ.

5. Museum Shop – Merch Product

БТ Дистрибьюшн ХХК нь 2023 оноос эхлэн “Археологийн хүрээлэн” болон “Чингис Хаан Үндэсний Музей”-н албан ёсны зөвшөөрлөөр байгалийн болон соёлын үнэт зүйлсийг агуулсан олдвор, зургуудыг олон нийтэд хүргэх, таниулан сурталчлах зорилгоор үнэ цэнэ, утга агуулгыг алдагдуулалгүйгээр загварчлан тохирох бүтээгдэхүүн дээр байршуулан мерч бүтээгдэхүүн гарган “Чингис Хаан Үндэсний Музей”-н “Museum Shop”-д нийлүүлэн ажиллаж байна.

Худалдаалагдаж буй мерч бүтээгдэхүүнээс заримыг дурдвал:

➤ Луун хээтэй тавган чимэглэл (Хоригийн өрөмтэй ваар)



Монголын эзэнт гүрний үеэс алтан ургийн хаад, язгууртныг таван сарвуутай луу, голгэсэртэн /Chrysanthemum/ цэцэгээр төлөөлүүлэн бэлгэддэг байжээ. Луу болон цэцэгээр дээл хувцас, сэнтий, цэргийн бүс, баярын цом аяганы бариул зэргийг чимдэг байв. Уг дүрслэлийг хослуулсан нь алтан ургийнхны сүр хүч эрх мэдэл үүрд мөнх оршин байхыг бэлгэджээ. Үүний тод жишээ нь Хөвсгөл аймгийн Их Хориг уулнаас олдсон өрөм хийсэн ваар юм.

- Халуун барьдаг усны сав 400мл
- Паалантай усны сав 300мл
- Паалантай аяга
- Дээд талдаа наалттай дэвтэр
- Хажуу талдаа наалттай дэвтэр
- А5 дэвтэр
- Төмөр бал зэрэг бүтээгдэхүүнүүдийг загварчлан худалдаанд гаргасан байна.



Бид хариуцлагатай хэрэглээг дэмжих зорилтын хүрээнд хог хаягдал цуглуулах, дахин ашиглах, байгальд шууд хаяхгүйгээр боловсруулах чиглэлд анхааран ажиллаж байгаагаас дурдвал:

Глобал Электроникс ХХК нь 2023 оны хэмжээнд 22,270ш хуруу зай, 1458ш койн баттерей худалдаалж үүнээс салбар дэлгүүрүүд болон худалдааны цэгүүдээр дамжуулан 5 хайрцаг хаягдал баттерей цуглуулсан байна.



Цуглуулсан хаягдал баттерейгаа байгальд шууд хаялгүйгээр холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулж байна.



- Глобал Нэгдэл ХХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд Хаягдал цаас дахин ашиглах, мод тарих, ногоон байгууламж бий болгох зэрэг ажлуудыг үе шаттайгаар хийж гүйцэтгэхээр төлөвлөн ажиллаж байна.
- Мөн “Хөдөлмөрийн Дотоод Журам”-ын 11.4 дэх заалтад энэхүү зорилтыг тусган хэрэгжүүлж байна.
- Манай борлуулдаг зарим бүтээгдэхүүний хувьд үйлдвэрлэгч компани өөрсдийн үйл ажиллагаандаа байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл явуулдаг буюу “Байгаль Орчны Бодлого” баримтлан ажилладаг. Жишээлбэл: Panasonic корпораци 2021 оны 10-р сарын 01 ний өдрөөс эхлэн дээрх бодлогын үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна.
- Глобал Нэгдэл ХХК - Бизнес Хөгжлийн Газар-ын үйл ажиллагаа, боловсруулж буй төсөл хөтөлбөрийн хүрээнд бид газрын нөхөн сэргээлт тэр дундаа газар тариалан, үр үржүүлгээр дамжуулан газрын хөрсийг нөхөн сэргээх боломжыг судлан ажиллаж байна. Үүнд бүх төрлийн газрын нөхөн сэргээлт тэр дундаа уул уурхайн газрын нөхөн сэргээлтийг гол чиглэл болгон судалж байгаа юм.



Глобал Нэгдэл-ийн “Хөдөлмөрийн Дотоод Журам”, “Ёс зүйн журам” болон холбогдох бусад журмуудыг ажилтан бүр даган мөрдөж ажилладаг ба шинээр ажилд орсон ажилтан эхний өдрөө уншиж танилцан, гарын үсгээ зурдаг. Ажилтнуудын ёс зүйн хэрэгжилтэд хяналт тавих, аливаа гомдол, маргааныг шийдвэрлэх үүднээс Ёс зүйн хороо ажилладаг.

“Хөдөлмөрийн Дотоод Журам”-ийн 10.2.5; 11.5.1

“Ёс Зүйн Журам”-ийн 5 дахь бүлэг 5.5; 5.6; 5.9.4; 5.9.6; 5.9.10 дахь заалтыг тус тус үндэслэн үйл ажиллагаа явуулдаг.

Энэхүү заалтууд нь авилгал, хээл хахуулийн бүх хэлбэрийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, биелүүлээгүй тохиолдолд авах арга хэмжээ зэрэгтэй холбоотой мөрдөгддөг.

“Ёс Зүйн Хороо”- ны бүрэлдэхүүн нь дараах байна:

Ёс зүйн хорооны дарга:

Глобал Нэгдэл ХХК-ийн Үйл Ажиллагааны Газрын захирал

Ёс зүйн хорооны нарийн бичиг:

Глобал Нэгдэл ХХК-ийн Хүний нөөцийн менежер

Ёс зүйн хорооны гишүүд:

Глобал Телеком ХХК-ийн гүйцэтгэх захирал

Глобал Электроникс ХХК-ийн гүйцэтгэх захирал

Глобалсмарт Сольюшн ХХК-ийн гүйцэтгэх захирал

